



# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.24. №81 (81)


## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ОХУ-Д АЖЛЫН АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА

Энэ сарын 22-24-ний өдрүүдэд ОХУ-д болж буй Олон улсын аюулгүй байдлын асуудлаарх Москвагийн 9 дүгээр бага хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тус улсын Батлан хамгаалахын сайд Сергей Кужугетович Шойгугийн урилгаар оролцож байна.

Айлчлалын үеэр Батлан хамгаалахын сайд Москва мужид байрлах “Патриот” цэргийн соёл амралтын хүрээлэнд Аугаа их Эх орны дайны ялалтад Монгол Улсын оролцоог харуулсан уран баримлын нээлтийн ёслолд оролцжээ. ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.Шойгу ёслолын ажиллагааг нээж хэлсэн үгэндээ “Өнөөдөр бид Аугаа ялалтыг байгуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Монгол болон Хятадын анд нөхдүүдэд зориулан эхний хоёр уран баримлын нээлтийг хийж байна. Дараа дараагийн жилд “Нормандия-Неман” Францын нисэхийн хороо, Аляскаас Сибирь лүү нисэх онгоц авч ирсэн Америкийн нисэгч нарт болон ялалтыг авчрахад тусалж дэмжиж байсан бүхэнд зориулж, уран баримлуудыг байршуулах болно” хэмээн онцолсон байна.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Аугаа их Эх орны дайны он жилүүдэд Монголын ард түмнээс Зөвлөлтийн ард түмэнд үзүүлсэн тусламжийг харуулсан дурсгалын хөшөөний нээлтийг хийж байгаад ОХУ-ын Батлан хамгаалахын сайд болон ОХУ-ын Батлан хамгаалах яамны бие бүрэлдэхүүнд хувиасаа болон Монголын нийт ард түмний нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлэе. Дайны турш 800 мянгаас ихгүй хүн амтай Монгол Улс “Бүхнийг фронтын төлөө, бүхнийг ялалтын төлөө” уриан дор бүх боломжоо дайчлан Зөвлөлтийн ард түмэнд тусламж үзүүлсэн явдалаар бид бахархдаг. Зөвлөлтийн ард түмэнд бэлэглэсэн Монгол морьд цэрэг дайчдын хамтаар Берлин хүрсэн байдаг. Москва хотын Хүндэтгэлийн дэнжид дайны он жилүүдэд Монгол морьдын үзүүлсэн агуу их гавьяаг харуулсан “Ялалтад тэмүүлсэн морьд” хөшөөг 2017 онд байршуулсан явдалд бид гүнээ талархаж явдгаа ОХУ-ын төр засагт дахин илэрхийлж байна” хэмээжээ.

Энэ үеэр хоёр орны Батлан хамгаалахын сайд нар чөлөөт ярилцлага



өрнүүлж, бусад төлөөлөгчийн хамтаар уран баримлын нээлтийн үйл ажиллагаанд зориулсан хүндэтгэлийн тоглолтыг үзэж сонирхсон аж. Түүнчлэн тэрээр Монгол

Улсын Элчин сайдын яамаар зочилж, ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Даваатай уулзалт хийжээ.

## ОЛОН УЛСЫН “АРАВТ” МОРИН ЦЭРГИЙН УРАЛДААНЫ ЭЦСИЙН ШАТНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ БОЛОВ



Олон улсын Зэвсэгт хүчнүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан итгэлцлийг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын үүрэггүйцэтгэх чадварыг нэмэгдүүлж харилцан туршлага солилцох зэрэг чухал ач холбогдолтой “Аравт” олон улсын морин цэргийн уралдааныг Монгол оронд зохион байгуулахаар бэлтгэл ажлын төлөвлөгөөг базааж байгаа бөгөөд уралдааны эцсийн шатны төлөвлөлтийн хурал өнөөдөр ҮБХИС-д зохион байгуулагддаг. Хуралд ЗХЖШ-ын I орлогч дарга, бригадын генерал

Ц.Жавхланбаатар, БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан, ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, МТГ-ын орлогч дарга, хурандаа Ц.Төрмөнх, СБЗХ-ийн дарга, хурандаа Ш.Гантулга, Зэвсэгт хүчний 345 дугаар бригадын захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ, ОХУ-ын ХЗЦК-ын байлдааны бэлтгэлийн хэлтсийн дарга, хурандаа А.К.Покровский, тус хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа, Э.Н.Исмаилов болон

албаны бусад хүмүүс оролцсон юм. Монгол Улстай Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаатай гадаадын 18 оронд эл уралдаанд оролцох урилгыг илгээсэн бөгөөд өнөөдрийн байдлаар ОХУ, Казакстан, Узбекистан, Иран, Зембаве зэрэг таван улс баг тамирчдаа, Япон Улс ажиглагч нараа оролцуулахаа албан ёсоор мэдэгдээд байгааг ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг хурлын үеэр тодотгов. Мөн тэрээр “Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал хүнд байгаа энэ цаг үед олон улсын “Аравт” морин

цэргийн уралдааныг зохион байгуулах шийдвэр гаргаж, бүх талын дэмжлэг үзүүлж байгаа Монгол Улсын Засгийн газар, БХЯ, Зэвсэгт хүчний удирдлага болон “Аравт” морин цэргийн уралдаанд оролцох багуудад талархаж байгаагаа илэрхийлсэн юм.

Үүний сацуу Монгол Улсын Зэвсэгт хүчин тус уралдааныг 2019 онд өөрийн оронд маш амжилттай зохион байгуулсан. Өнөө жил ч амжилттай зохион байгуулж чадна гэдэгтээ би итгэлтэй байна. Коронавируст цар тахлын халдварын хүнд нөхцөл байдал нь энэхүү уралдааныг амжилттай, эрсдэлгүй зохион байгуулахад ихээхэн сөрөг нөлөөг үзүүлж байна. Гэсэн хэдий ч энэхүү уралдааныг амжилттай, эрсдэлгүй зохион байгуулах нь Та бидний хариуцлага, зохион байгуулалтаас шууд хамаарна. Тийм учраас өнөөдрийн эцсийн шатны хуралдаанаараа уралдааныг зохион байгуулахтай холбоотой асуудлыг бүх талаас нь хэлэлцэн, харилцан тохиролцож, аливаа зүйлийг жижиг гэлтгүй шүүн ярилцах учиртай гэдгийг чухалчилж байв.

Сонирхуулахад энэ жилийн тэмцээний алсын зайн морин маршийн төрөлд баг тамирчдын тэсвэр хатуужил, эр зориг, ур чадварыг илүү ихээр сорино. Учир нь тодорхой зайд морио хөтөлж, бартаа саадыг явганаар туулах ёстой аж.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	🌧️ 12

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 24

#### АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 16

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.469.00	3.428.00
CNY 🇨🇳	437.80	441.60
RUB 🇷🇺	38.50	40.20
JPY 🇯🇵	25.44	25.93
KRW 🇰🇷	2.42	2.56

### ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 15  
2021.06.24.  
/ПҮРЭВ ГАРАГ/

#### ЗУНЫ ДҮНД ХӨХ МОРЬ САР ДӨРВӨН НОГООН ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингэх:  
04.53-20.55

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Хий

Арвын тооллын 1 сарын 24, Бархасвадь гараа. Билгийн тооллын 19, Бага морь одтой, цагаагчин тахиа өдөр. Өдрийн наран 8 цаг 39 минутад мандан, 17 цаг 39 минутад жаргана. Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, лусыг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

100.263

ЭДГЭРСЭН

65.547

НАС БАРСАН

469/10

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

319753)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

352

ЭДГЭРСЭН

2790

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 179,245,386

Эдгэрсэн

Нийт: 163,798,559

Нас барсан

Нийт: 3,881,890



# ХОЛБООЧИД УР ЧАДВАРААРАА ӨРСӨЛДӨЖ БАЙНА



Зэвсэгт хүчний цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээний нэг хэсэг болох хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит "Холбоочдын цогцолбор тэмцээн" 3 дахь өдрөө цахим технологи ашиглан явагдаж байна. Тэмцээнд Зэвсэгт хүчин, ХХЕГ, ОБЕГ-ын 16 баг тамирчид өндөр хурдны радио телеграф, зохион бүтээх, компьютер, сүлжээний болон эсээ бичлэгийн ур чадвараараа багийн болон хувийн төрлөөр өрсөлдөж байна. Уг тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулсан туршлага одоогоор дэлхийд байхгүй бөгөөд Олон улсын радио спортын холбооны өндөр цол зэрэгтэй шүүгчид ажиглаж, цаашид энэ төрлийн олон улсын тэмцээнийг цахим хэлбэрээр явуулах боломжийг тодорхойлно хэмээн зохион байгуулагчид онцолж байна.

# ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ҮЗЭГЧГҮЙ ЗОХИОН БАЙГУУЛНА



## ХАНДИВЫН АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



үеийн төгсөгчид болон байнгын бүрэлдэхүүнийг энэхүү хандивын аянд идэвх санаачилгатай оролцохыг уриалж байгаа юм. Мөн энэ үеэр хандивын аяныг эхлүүлж Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хошууч генерал О.Уржин, ҮБХИС-ийн тэргүүлэх профессор, Ардын багш, хурандаа Г.Мягмаржав нар тус бүр нэг сая төгрөгийг төрөлх сургуулийнхаа ойд зориулан хандивлалаа. Сонирхуулахад ҮБХИС нь 100 жилийнхээ түүхэн хугацаанд 70 мянга гаруй сонсогчийг төгсгөж, улс эх орноо Батлан хамгаалах их үйлс Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшлийн төлөө үүргээ манлайлан гүйцэтгэж байгаа Монгол Улсын боловсролын ууган байгууллага юм.

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт ҮБХИС-ийн түүхт 100 жилийн ой ирэх 10 дугаар сард тохиох юм. Тус ойг тэмдэглэн өнгөрүүлэх Салбар зөвлөл, Дэд

зөвлөлийн шийдвэрээр хандивын аяныг эхлүүлэх төлөвлөлтийн хурлыг өчигдөр зохион байгууллаа. Энэ хүрээнд ҮБХИС-ийн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Салбар зөвлөлөөс үе

**Коронавируст** халдварын цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцууллаа.

Үйл ажиллагааг нь нээсэн худалдаа, үйлчилгээний салбаруудын цагийн хуваарьт хязгаарлалт, зохицуулалт хийж халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллаж байна. Тухайлбал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг 2021 оны зургадугаар сарын 17-ны өдрөөс эхлэн долоо хоногийн хугацаатай заалаар үйлчлэхийг хориглож, амралт жуулчны баазын үйл ажиллагааг энэ сарын 17-ны өдрөөс долоо хоног хязгаарлалаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ цар тахлын энэ үед аймаг, сумын наадам хийхгүй, Үндэсний их баяр наадмыг үзэгчгүй зохион байгуулах чиглэл өглөө. Хэмнэгдэх зардлыг цар тахлын хариу арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй гэлээ.

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулав. Коронавируст халдвар цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгаа сэргээх зорилготой 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Ажлын байрыг дэмжих зорилгоор энэ сарын 14-ний өдрийн байдлаар 65,7 хувь, репо санхүүжилтийн зээл олголт 24,9 хувь, орон сууцны ипотекийн зээл олголт 2021 онд төлөвлөсөн хэмжээний 38 хувьд хүрээд байна. Мөн 15784 зээлдэгчдэд хөдөө аж ахуйг дэмжсэн 207,5 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг банкнуудын чөлөөт эх үүсвэрээр олгож, зээлийн батлан даалтын

сангийн тогтолцоог ашиглах зохицуулалт хийж байна.

Энэ сарын 14-ний байдлаар нийт 6,060.9 тэрбум төгрөгийн 57.7 мянган зээлийн хүсэлт ирүүлснээс 1,313.8 тэрбум төгрөгийг нийт 17785 иргэн, аж ахуйн нэгжид олгоод байна.

Агаарын тээвэр, аялал жуулчлалын талаар дараах арга хэмжээг авна. Аялал жуулчлал болон агаарын тээврийн салбарыг богино хугацаанд эргэн сэргээх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий Агаарын тээвэр, аялал жуулчлалын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол гаргахаар болов.

Тогтоолд агаарын тээвэр болон аялал жуулчлалын салбарыг харилцан уялдаатай хөгжүүлэх хамтарсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, жуулчин тээврийн нислэгийн тоо, давтамж, чиглэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах зохицуулалт бүрдүүлэхээр тусгалаа.

Мөн аялал жуулчлалыг дэмжих тусгай тарифын бодлого баримталж, гадаадын улс оронд сурталчлан таниулах, жуулчны урсгал, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан шинээр нислэгийн чиглэл нээх, нислэгийн суудал ашиглалт үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм байна.

Аймгууд Соёлын хэлтэстэй боллоо. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төсөлд өөрчлөлт оруулж "Боловсрол, соёл урлагийн газар" гэснийг Боловсролын газар, Соёлын хэлтэс гэж өөрчилж, соёл урлагийн чиг үүргийг орон тоо, цалингийн сан, түүнд ногдох үйл ажиллагааны зардлын хамт шинээр байгуулах Соёлын хэлтэст холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь хэвийн явуулах нөхцөлөөр хангахыг холбогдох хүмүүст үүрэг болголоо.

Соёлын хэлтэс бий болсноор соёлын үйлчилгээний чанар,

хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амыг бүх нийтийн соёлын боловсролоор дамжуулан соён гэгээрүүлэх, соёлын өвөө хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх төрийн соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймагт байгуулна.

Архангай, Дархан-уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засах цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, тэдний хөгжлийг дэмжих чиг үүрэг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулна.

Дээрх аймгуудад төвийн барилгын ажлыг эхлүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэж байна. Төвүүдийн үйл ажиллагааг 2022 оноос эхлүүлэхээр төлөвлөжээ. Товч мэдээ

□ Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтэн Манлай баатар Жамсрангийн Д а м д и н с ү р э н г и й н мөндөрсний 150 жилийн ойг 2021 онд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

□ Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулийн төслүүдийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

□ Монгол Улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газар хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг хэлэлцэн батлав. Бүгд Найрамдах Сингапур Улс, Шинэ Зеланд Улс, Бүгд Найрамдах Эстони Куба Улс болон Өмнөд Америкийн зарим улстай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын түвшний хамтарсан механизм байгуулах чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгав гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газраас мэдээллээ.

## ЦАХИМ ШУУДАНД

### УВС АЙМГИЙН 19 СУМ "ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТЫН ТАНХИМ"-ТАЙ БОЛОВ

Увс аймгийн ЗДТГ-ЫН Цэргийн штаб

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Батлан хамгаалахын сайдын Увс аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээнд "Орон нутгийн хамгаалалтын сургалтын танхим" байгуулж, ашиглалтад оруулах талаар тусгасан. Энэ ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас санаачлан 19 суманд "Орон



нутгийн хамгаалалтын сургалтын танхим"-ыг сумдын ЗДТГ-тай хамтран тохижуулж ашиглалтад орууллаа. Ийм танхимтай болсноор Орон нутгийн хамгаалалтын

томилгоот нэгжийн удирдах болон нийт бүрэлдэхүүний сургалтуудыг явуулах орчин нөхцөл бүрдэж байгаа юм.

Хошууч Ж.ЦЭРЭНЧИМЭД

## ДЭЛХИЙД

### КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ ОЛЖ ТОГТООХТОЙ ХОЛБОГДУУЛАН ХЯТАДУУДАД АНХААРУУЛГА ӨГЛӨӨ

Доктор (Ph.D), хурандаа Р.ЭНХБОЛД

АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөх Жак Салливан нь мэдээллийн "Fox" телевизэд өгсөн ярилцлагын үеэр "Хятадууд коронавируст халдвар /КОВИД-19/-ын эх үүсвэрийг олж тогтоох ажилд хамтран оролцохгүй бол олон улсын зүгээс тусгаарлагдах асуудалтай тулгарч болзошгүй" гэдгийг анхааруулжээ. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден 2021 оны 5 дугаар сард Америкийн тагнуулын байгууллагад 90 хоногийн дотор уг вирусийн эх үүсвэрийг олж тогтоох



даалгавар өгсөн ба үүнийг биелүүлэхийн тулд Америкийн тагнуулын байгууллагаас өөрсдийн түнш улс орнууд, олон

улсын байгууллага, түүний дотор хятадуудтай хамтран ажиллах нь чухал асуудал болоод байгаа юм.

Эх сурвалж: sputniknews.com